

Ерөнхийлөгч
Диетер Ф.Угдорф

Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар Зөвлөх



Бидэнд яагаад бошиглогчид хэрэгтэй байдаг вэ?

Тэнгэрлэг Эцэг Өөрийн хүүхдүүдээ хайртай болохоор тэднийг энэ мөнх бус амьдралд удирдамж болон чиглүүлэлгүй үлдээгээгүй юм. Тэнгэрлэг Эцэгийн сургаалууд нь номын дэлгүүрээс худалдаж авч болох ямар нэгэн эгэл жирийн, хэн ч тааварлаж болох зүйл биш юм. Тэдгээр нь хүүхдүүдээ хайртай бүх хүч чадал, бүх мэдлэгийг эзэмшдэг селестиа Хүмүүний мэргэн ухаан билээ. Түүний үгс цаг үеийн нууцууд болон энэ дэлхий хийгээд ирэх амьдрал дахь аз жаргалын түлхүүрийг агуулдаг.

Тэнгэрлэг Эцэг энэхүү мэргэн ухааныг энэ дэлхий дээр Өөрийн үйлчлэгч бошиглогчдоороо дамжуулан хүүхдүүдээ илчилдэг билээ (Амос 3:7-г үз). Бурхан Адамын үеэс эхлэн Түүний тааллыг илчилж, бусдад зөвлөх үүрэгт томилогдсон бошиглогчдоороо дамжуулж хүүхдүүдтэйгээ ярилцдаг байжээ. Бошиглогчид бол сүнслэг багш нар бөгөөд үргэлж Есүс Христийн онцгой гэрч нар байсаар ирсэн (С ба Г 107:23-г үз). Бошиглогчид өөрсдийн цаг үед амьдарч байсан хүмүүст хандан ярьдаг байсан төдийгүй бүх цаг үеийн хүмүүст хандан ярьдаг юм. Тэдний дуу хоолой Бурханы Өөрийн хүүхдүүдэд өгөх гэрээслэл болсоор зуун зууныг дамжин цуурайтаж байна.

Өнөөгийн цаг үе өнгөрсөн үеэс ялгаагүй билээ. Өнөө үеийн хүмүүсийг хайрлах Их Эзэний хайр нь өнгөрсөн үеийнхнийг хайрлах хайраас огтхон ч ялгаагүй билээ. Бурхан Өөрийн хүүхдүүдтэйгээ ярилцсаар байгаа гэдэг нь Есүс Христийн Сүмийн Сэргээлтийн алдар суут захиасуудын нэг билээ. Тэрбээр тэнгэрийн хаа нэгтээ далдлагдаагүй бөгөөд эрт үеийн адилаар өнөөдөр ч ярьдаг юм.

Их Эзэний Өөрийн бошиглогч нарт илчилсэн илчлэлтүүдийн ихэнх нь хувь хүн болоод улс нийгмийг гуниг харууслаас хамгаалахад чиглэсэн байдаг. Бурхан хүүхдүүдээ зааж, тэднийг урамшуулан, анхааруулж, дэмждэг билээ. Хувь хүмүүс болоод нийгэм Тэнгэрлэг Эцэгийн зааврыг үл ойшоох үедээ өөрсдийгөө зовлон бэрхшээл, сорилт шалгуурын хөлд тавьж өгч байдаг.

Бурхан Өөрийн бүх хүүхдүүдэд хайртай. Ийм учраас л Тэрээр биднийг Өөрийн бошиглогчдоороо дамжуулан өмгөөлөн хамгаалж, зааварчилдаг билээ. Бид хайртай хүмүүстээ хамгийн сайн сайхныг хүсдэгийн адил Тэнгэрлэг Эцэг бидэнд хамгийн сайн сайхныг хүсдэг билээ. Ийм учраас Түүний зааврууд маш чухал агаад үнэхээр шаардлагатай байдаг. Ийм учраас Тэрээр биднийг орхиогүй бөгөөд Өөрийн тааллыг бошиглогчдоороо

дамжуулан бидэнд илчилсээр байгаа билээ. Бидний болон дэлхий ертөнцийн хувь тавилан Бурханы илчилж, хэлсэн үгсийг бид хэр сонсон дагаж байгаагаас шалтгаална.

Бурханы хүн төрөлхтөнд өгсөн үнэлж баршгүй заавруудыг бид Библи, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ болон Агуу үнэт сувдаас олох боломжтой. Нэмж хэлэхэд Их Эзэн Өөрийн үйлчлэгчдээрээ дамжуулан бидэнтэй ярьдаг, мөн Тэрээр ирэх ерөнхий чуулганд ч ярих болно.

“Бурхан өнөөдөр бидэнд хандан ярих боломжтой гэж үү” хэмээн гайхаж, асуух тэднийг би “ирж, хар л даа” (Иохан 1:46) гэж зүрх сэтгэлээсээ урьмаар байна. Судрууд дээр гардаг Бурханы үгсийг унш. Ерөнхий Чуулганаар хожмын үеийн бошиглогчдоороо дамжуулан ярих Бурханы дуу хоолойг анхааралтай сонс. Ирж сонсоод, зүрх сэтгэлээрээ мэдэр! Хэрэв та нар “Христэд итгэлтэй байж, чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр асуух аваас, тэрбээр үүний үнэнийг Ариун Сүнсний хүчээр та нарт мэдүүлэх болно” (Моронай 10:4). Энэхүү хүчээр дамжуулан би Есүс Христ амьд бөгөөд амьд бошиглогч Томас С.Монсонгоор дамжуулан Өөрийн Сүмийг удирддаг гэдгийг мэдэж авсан юм.

Ах эгч нар аа, Бурхан өнөөдөр ч бидэнд хандан ярьдаг. Мөн Тэрээр Өөрийн бүх хүүхдүүдийг Түүний дуу хоолойг сонсож, дагаасай хэмээн хүсдэг. Бид ийн үйлдсэнээр Их Эзэн энэ амьдралд болоод ирэх амьдралд биднийг агуу ихээр адисалж, дэмжих болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Амьд бошиглогчоор удирдуулах нь

Кристи Рипа

Би 16 настай байхдаа анх удаагаа биечлэн ерөнхий чуулганыг үзсэн юм. Манай гэр бүл АНУ-ийн баруун өрнөд Ореганд амьдардаг байсан ба бид ерөнхий чуулганд оролцохоор Юта руу машинаар явсан юм. Замын дунд ах маань номлогчийг бэлтгэх төвд бууж үлдсэн билээ.

Би ерөнхий чуулган дээр Ариун Сүнсээр заалгах маш их хүсэлтэй байлаа. Эцэст нь хэрэв би өөрийгөө бэлтгэхгүй бол Сүнснээс удирдамж хүлээж авахгүй гэсэн мэдрэмжийг Сүнснээс хүлээн авсан юм.

Хуралдааны үеэр бүх хүмүүс босж зогсоод “Guide Us, O Thou Great Jehovah” дууллыг дуулж байлаа. Тэднийг дуулж байх үед надад Чуулганы Төвийг нэг сайн ажин харья гэсэн мэдрэмж төрж билээ. Бурханыг магтан дуулахын тулд дуу хоолойгоо өргөж байгаа мянга мянган хүний эв нэгдлийн хүчийг би гайхширсан юм.

Би Нифай амьдралын модны үзэгдлийг харах үедээ мэдэрсэн мэдрэмжийг мэдэрсэн бөгөөд Сүнс надад “Харагтун” (1 Нифай 11–14-г үз) хэмээсэн билээ. Би Ерөнхийлөгч Томас С.Монсон руу харж, бид амьд бошиглогчоор удирдуулдаг болохоор Сүмд эв нэгдэл оршдог гэдгийг мэдэрсэн. Ариун Сүнсний гэрчлэлээр дамжуулан би Ерөнхийлөгч Монсон өнөө үеийн үнэн бошиглогч бөгөөд Есүс Христ энэ Сүмийг түүгээр дамжуулан удирддаг гэдгийг мэдэж авсан.



Итгэл, Гэр бүл, Халамж

Daughters in My Kingdom

Энэ материалыг судалж, гэрээр нь очиж заадаг эгч нартай аль болох тохиромжтой арга замаар ярилц. Эгч нарын итгэлийг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг тэдний амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Бид Тэнгэр дэх Эцэгийн охид билээ. Тэрээр биднийг мэддэг, хайрладаг мөн бидэнд зориулсан төлөвлөгөөг бэлдсэн. Энэхүү төлөвлөгөөний нэг хэсэг нь муугаас илүүтэйгээр сайныг сонгохоор энэ дэлхийд ирэх явдал билээ. Бид Бурханы зарлигуудыг дагахаар сонгох үедээ Түүнийг хүндэтгэн биширч, Бурханы охид болох хувь заяагаа хүлээн зөвшөөрдөг. Нийгмийн Халамжийн бүлэг бидэнд энэхүү тэнгэрлэг өвөө санахад тусалдаг.

Нийгмийн Халамжийн бүлэг болон түүний түүх нь биднийг хүчирхэгжүүлэн дэмждэг билээ. Нийгмийн Халамжийн бүлгийн ерөнхий ерөнхийлөгч Жюли Б.Бек эгч ийн хэлсэн юм “Бурханы охидын хувьд та мөнхийн зорилгод бэлдэж байгаа бөгөөд та нарын хүн нэг бүр эмэгтэй хүний шинж чанар, үүрэг хариуцлагатай юм. Гэр бүлүүдийн болон нийгэм хороод, Сүмийн амжилт мөн гайхамшигт авралын төлөвлөгөө таны итгэлээс шалтгаалдаг билээ. . . . [Бидний Тэнгэрлэг Эцэг] Өөрийн хүмүүсийг барьж босгож, тэднийг ариун сүмийн адислалуудад бэлтгэхэд туслахын тулд Нийгмийн Халамжийн бүлгийг зохион байгуулсан билээ. Тэрээр [Нийгмийн Халамжийн бүлгийг] охидоо Өөрийн

ажилдаа нэгтгэж, Өөрийн хаант улсыг байгуулахад болон Сионыг хүчирхэгжүүлэхэд тэдний тусалцааг цэдгэлэхийн тулд байгуулсан билээ.”¹

Тэнгэр дэх Эцэг маань Түүний Хаант улсыг байгуулахад туслах тодорхой үүрэг даалгавруудыг бид бүгдэд өгсөн байдаг. Мөн Тэрбээр тэдгээр тодорхой үүрэг даалгавруудыг гүйцэтгэхэд бидэнд туслах сүнслэг бэлгүүдээр биднийг адисалсан байдаг. Нийгмийн Халамжийн бүлгээр дамжуулан бид гэр бүлүүдийг хүчирхэгжүүлж, тусламж хэрэгтэй байгаа хүмүүст хүрч, Есүс Христийн шавь байхын тулд хэрхэн амьдрахад суралцахадаа өөрсдийн бэлгийг ашиглах боломжтой болдог.

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф шавь байх талаар ийнхүү хэлсэн билээ: “Бид дагалдагчийн замаар тэвчээртэйгээр алхсанаар итгэлийнхээ хэмжүүр болон өөрсдийнхөөсөө илүүтэйгээр Бурханы хүслийг дагах сэтгэлээ баттай болгодог.”²

Бид Бурханы охид гэдгээ санаж, Түүний дагалдагчын амьдралаар амьдрахын төлөө тэмцэх болтугай. Бид ийн үйлдсэнээр дэлхий дээрх Бурханы хаант улсыг байгуулахад тусалж, Түүний оршихуйд эргэж очих зохистой болно.

Бидний түүхээс

1842 оны 4-р сарын 28-нд Бошиглогч Иосеф Смит Нийгмийн Халамжийн бүлгийн эгч нарт хандан “Та бүгд онцгой боломжиндоо тохирохоор амьдрах аваас тэнгэр элчүүд та нартай хамтран ажиллахаас татгалзаж чадахгүй” хэмээн хэлсэн билээ.”³

Бусдад үйлчилж, хувь хүмүүст итгэлээ хөгжүүлэхэд нь туслах Нийгмийн Халамжийн бүлгийн хүч чадлын талаар Нийгмийн Халамжийн бүлгийн гурав дахь ерөнхий ерөнхийлөгч Зина Д. Х.Янг 1893 онд эгч нарт ийнхүү амлажээ “Хэрэв та нар зүрх сэтгэлийнхээ гүн рүү Их Эзэний Сүнсний тусламжтайгаар өнгийх аваас энэхүү ажлын гэрчлэл болох агуу үнэт сувдыг олох болно.”⁴

Эшлэл

1. Жюли Б.Бек “‘Daughters in My Kingdom’: The History and Work of Relief Society,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 112, 114.
2. Диетер Ф.Угдорф, “The Way of the Disciple,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 76.
3. Иосеф Смит, *History of the Church*, 4:605.
4. Зина Д. Х.Янг, “How I Gained My Testimony of the Truth,” *Young Woman's Journal*, 1893 оны 4-р сар, 319.

Судруудаас

Зехариа 2:10; Сургаал ба Гэрээ 25:1, 10, 16; 138:38–39, 56; “Тэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” (*Лиакхона* мөн *Ensign*, 2010 оны 11-р сар, 129)

Би юу хийж чадах вэ?

- 1.** Бурханы охидын хувьд өөрсдийн боломжоо бүрэн ашиглахад нь би эгч нарт хэрхэн туслах вэ?
- 2.** Сургаал ба Гэрээ 25-р бүлэгт гардаг эгч нарт өгсөн анхааруулга болон зөвлөгөөг би хэрхэн амьдралдаа хэрэгжүүлэх вэ?

Нэмэлт мэдээллийг
reliefsociety.lds.org-аас үзнэ үү.